



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар Н/47

Улаанбаатар хот

Тэтгэлэгт хөтөлбөрөөр гадаадад
суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын 2015 оны 12 дугаар сард байгуулсан Сургалтын хамтарсан тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр, хамтарсан сонгон шалгаруулалтын дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дээд боловсролын хамтарсан тэтгэлгийн хөтөлбөрийн хүрээнд хавсралтад нэр дурдсан 5 иргэнийг 2022-2023 оны хичээлийн жилээс Бүгд Найрамдах Франц Улсын их, дээд сургуулийн магистрантурт суралцуулсугай.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, зохих журмын дагуу холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /Д.Гарди /-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар /Ш.Нарантуяа/-д нарт тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142210902

Боловсрол, шинжлэх ухаан сайдын
2022 оны 7 дугаар сарын 05-ны
өдрийн 117 тушаалын хавсралт

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР
БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ХАМТАРСАН
ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД МАГИСТРЫН
СУРГАЛТАД ХАМРАГДАХ ИРГЭДИЙН НЭРС

№	Овог	Нэр	Суралцах хугацаа	Мэргэжлийн чиглэл	Суралцах сургууль
1	Энхбаяр	Номин	2	Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутгийн хүрээлэн буй орчны хөгжил	University of Strasbourg
2	Лхагважав	Дагваноров	2	Компьютерийн шинжлэх ухаан	Ecole Polytechnique
3	Баттөр	Хатантуул	1	Малын эрүүл мэндийн шинжлэх ухаан	National School of Veterinary Services
4	Хосхүү	Идэр	2	Олон улсын харилцаа ба хөгжил	Paris Dauphine University
5	Рагчаа	Очирбал	2	Олон улсын эрх зүй	University of Toulouse